

УЛС ХООРОНДЫН ОРОХ ЯРИАНЫ ТАРИФЫН МӨРДӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Харилцаа холбооны зохицуулах зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэнэ/-ноос тогтоосон улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифын доод хязгаар, улс хоорондын яриаг нэгдсэн станцаар дамжуулсны төлбөр, улс хоорондын орох яриаг үүрэн, суурин, утасгүй суурин сүлжээнд төгсгөх тарифыг улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, улс хоорондын ярианы зах зээлийн байдалд дүн шинжилгээ хийх, улс хоорондын ярианы үйлчилгээний зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид, улс хоорондын ярианы нэгдсэн станцыг эзэмшигч болон Зохицуулах хороо нь энэхүү журмыг мөрдөхдөө “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль”, “Харилцаа холбооны тухай хууль”, “Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”, “Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрээ” болон тэдгээртэй холбогдон гарсан бусад шийдвэр, баримт бичгийг удирдлага болгоно.

Хоёр. Зохицуулах хорооны эрх, үүрэг

2.1. Зохицуулах хорооны эрх:

- 2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид нь улс хоорондын орох болон гарах ярианы ачааллаа улс хоорондын нэгдсэн станцаар дамжуулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих.
- 2.1.2. Улс хоорондын ярианы орох гарах ачааллын мэдээллийг үйлчлэгчид болон нэгдсэн станцаас дараа сар бүрийн 15-ны дотор гаргуулан авах.
- 2.1.3. Улс хоорондын яриаг оруулах, гаргах, дамжуулах талаар гадаадын байгууллагууд болон үйлчлэгчдийн хооронд хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцлүүд, гэрээнд оруулсан өөрчлөлтүүдийг зөвхөн албан хэрэгцээнд зориулан үйлчлэгчдээс тухай бүр гаргуулан авах.
- 2.1.4. Улс хоорондын яриаг оруулах, гаргах, дамжуулах талаар гадаадын байгууллагууд болон үйлчлэгчдийн хооронд хийсэн бүх гэрээний дагуу тооцоо нийлсэн санхүүгийн акт, төлбөр тооцооны баримтыг дараа сар бүрийн 30-ны дотор гаргуулан авах, газар дээр нь танилцаж баталгаажуулах.
- 2.1.5. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээд, нэгдсэн станц, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын дагуу шаардлагатай хяналт шалгалтыг явуулах, үүрэг даалгавар өгөх.
- 2.1.6. Зохицуулах хорооноос тогтоосон улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифын доод хязгаар, улс хоорондын яриаг нэгдсэн станцаар

дамжуулсны төлбөр, улс хоорондын орох яриаг үүрэн, суурин, утасгүй суурин сүлжээнд төгсгөх тарифыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, эдгээр тарифыг мөрдөхөөс зайлсхийсэн, зөрчсөн үйлчлэгчдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах.

2.1.7. Энэхүү журмаар олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналтын үйл ажиллагаа явуулах явцдаа шаардлагатай гэж үзвэл холбогдох татварын болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

3.4. Зохицуулах хорооны үүрэг:

2.2.1. Үйлчлэгчдийн гаргаж өгсөн болон тэдгээртэй холбогдох мэдээллийн нууцлалыг холбогдох хууль, дүрмийн дагуу хадгалах.

2.2.2. Улс хоорондын ярианы үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөөний нөхцлийг хангах.

2.2.3. Зохицуулах хорооноос тогтоосон улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифын доод хязгаар, улс хоорондын яриаг нэгдсэн станцаар дамжуулсны төлбөр, улс хоорондын орох яриаг үүрэн, суурин, утасгүй суурин сүлжээнд төгсгөх тарифыг мөрдөхөөс зайлхийсэн, зөрчсөн үйлдэл гаргасан үйлчлэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан бусад үйлчлэгчдэд учирсан хохирлын хэмжээг тогтооход дэмжлэг үзүүлэх.

2.2.4. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээд, нэгдсэн станц, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдол саналыг өөрт олгогдсон эрх, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай хүлээн авч, хянан шийдвэрлэх, үр дүнг гомдол гаргагч этгээдэд болон нийтэд мэдээлэх.

2.2.5. Улс хоорондын яриа дамжуулах нэгдсэн станцын техникийн хэвийн үйл ажиллагааг хангах, техникийн нөхцлийг бүрдүүлэх талаар улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчидтэй хамтын хяналт тавих, дэмжлэг үзүүлэх.

Гурав. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг

3.1. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчийн эрх:

3.1.1. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгч бусад этгээд, нэгдсэн станцын үйл ажиллагааны талаар гомдол саналаа шууд бие даан болон төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан Зохицуулах хороонд гаргах, шийдвэрлүүлэх.

3.1.2. Зохицуулах хороонд гаргаж өгсөн өөрийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийн нууцлалыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хадгалахыг тус Зохицуулах хорооноос шаардах.

3.2. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчийн үүрэг:

3.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид нь улс хоорондын орох болон гарах ярианы ачааллаа улс хоорондын нэгдсэн станцаар дамжуулах.

3.2.2. Улс хоорондын ярианы орох, гарах ачааллын мэдээллээ Зохицуулах хороонд дараа сар бүрийн 15-ны дотор саадгүй гаргаж өгөх.

3.2.3. Улс хоорондын яриаг оруулах, гаргах, дамжуулах талаар гадаадын байгууллагуудтай байгуулсан бүх гэрээ, гэрээний нөхцлүүд, гэрээнд оруулсан өөрчлөлтүүдийг тухай бүр Зохицуулах хороонд саадгүй гаргаж өгөх.

- 3.2.4. Улс хоорондын яриаг оруулах, гаргах, дамжуулах талаар гадаадын байгууллагуудтай байгуулсан аливаа гэрээнийхээ дагуу тооцоо нийлсэн бүх санхүүгийн акт, төлбөр тооцооны баримтыг дараа сар бүрийн 30-ний дотор Зохицуулах хороонд саадгүй гаргаж өгөх.
- 3.2.5. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээд, нэгдсэн станц, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын дагуу Зохицуулах хороо нь хийж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх.

Дөрөв. Улс хоорондын ярианы ачааллыг дамжуулах нэгдсэн станц эзэмшигчийн эрх, үүрэг

- 4.1. Улс хоорондын ярианы ачааллыг дамжуулах нэгдсэн станц эзэмшигчийн эрх:
 - 4.1.1. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид болон холбогдох бусад этгээдийн үйл ажиллагааны талаар гомдол, саналаа шууд бие даан болон төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан Зохицуулах хороонд гаргах, шийдвэрлүүлэх.
 - 4.1.2. Зохицуулах хороонд гаргаж өгсөн өөрийн болон улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийн нууцлалыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хадгалахыг тус Зохицуулах хорооноос шаардах.
- 4.2. Улс хоорондын ярианы ачааллыг дамжуулах нэгдсэн станц эзэмшигчийн үүрэг:
 - 4.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчдийн улс хоорондын орох болон гарах ярианы ачааллыг техникийн нөхцөл шаардлага, чанарын стандарт, улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчидтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу саадгүй дамжуулах.
 - 4.2.2. Өөрийн станцаар дамжуулсан улс хоорондын ярианы орох гарах ачааллын мэдээллийг үйлчилгээ эрхлэгч тус бүрээр Зохицуулах хороонд дараа сар бүрийн 15-ны дотор саадгүй гаргаж өгөх.
 - 4.2.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэхгүй байх ба улс хоорондын яриаг гаргах, дамжуулах, оруулах талаар гадаадын ямар ч байгууллагатай гэрээ байгуулах болон гэрээ байгуулах оролдлого хийхгүй байх..
 - 4.2.4. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын дагуу Зохицуулах хорооноос хийж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх.

Тав. Хяналт тавих аргачлал.

- 5.1. Зохицуулах хороо нь улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифид дараахь аргачлалын дагуу хяналт тавина.
 - 5.1.1. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгч тус бүрийн ирүүлсэн ачааллын мэдээллийг нэгдсэн станцын тоолсон ачаалалтай харьцуулан мэдээллийн үнэн зөв байдлыг тогтоох.

- 5.1.2. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгч бүрийн нотлогдсон ачааллыг улс хоорондын яриаг оруулах, гаргах, дамжуулах талаар гадаадын байгууллагуудтай байгуулсан аливаа гэрээнийхээ дагуу тооцоо нийлсэн бүх санхүүгийн акт, төлбөр тооцооны баримттай харьцуулан тухайн үйлчилгээ эрхлэгчийн мөрдөж буй гадаад тооцооны тарифыг тогтоох.
- 5.1.3. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгч бүрийн мөрдөж буй улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифыг Зохицуулах хорооноос тогтоосон тарифын доод хязгаартай харьцуулан дүгнэлт гаргах.
- 5.1.4. Тухайн үйлчлэгч нь Зохицуулах хорооноос тогтоосон улс хоорондын орох ярианы гадаад тооцооны тарифын доод хязгаарыг зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан хэдий ч тэр үйлдэл нь бүрэн нотлогдохгүй байвал Зохицуулах хороо нь өөрийн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд дахин газар дээр нь хяналт шалгалт явуулах ба хяналтын үйл ажиллагаа явуулах явцдаа шаардлагатай гэж үзвэл холбогдох татварын болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллаж эцсийн дүгнэлтийг гаргана.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргаан шийдвэрлэх журам” болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 6.2. Маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Зохицуулах хороо дараахь аргуудыг хэрэглэж болно. Үүнд:
 - 6.2.1. Маргаантай асуудлыг судлахын тулд шаардлагатай мэдээллийг талуудаас авах;
 - 6.2.2. Авсан мэдээллийг судлах, дүн шинжилгээ хийх, баримт гаргаж тавих;
 - 6.2.3. Шаардлагатай бол хэмжилт, шалгалтыг хийх, факт гаргаж тавих;
 - 6.2.4. Маргалдагч талуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын бус зөвлөлийг Зохицуулах хороо санаачлан байгуулж, тухайн асуудлаар санал солилцуулан нэгдсэн шийдвэрт хүргэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах.
- 6.3. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар гаргах шийдвэрийнхээ тухай урьдчилан талуудад танилцуулж саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх зэргээр ил тод зарчмыг баримтлана.
- 6.4. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар тухайн нөхцөл байдалд тохируулан ялгаварлахгүй, хүнд сурталгүйгээр, шударга, өрсөлдөөнийг дэмжсэн шийдвэр гаргана.
- 6.5. Зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

Долоо. Хариуцлага

- 7.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:
 - 7.1.1. Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;

- 7.1.2. Захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх;
- 7.1.3. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;
- 7.1.4. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;
- 7.1.5. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох.

----- о О о -----